



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/106

Хэрлэн сум

**Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батламжлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.30 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүнээс Ч.Баярцолмон, Б.Энхболор нарын албан тушаал өөрчлөгдсөн, Д.Оюунбаяр Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчийн Хуралд сонгогдсон, Р.Байгалмаа өөрийн хүсэлтээр өргөдлөө өгч Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдсөн тул Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг эгүүлэн татаж, Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн батламжилсугай.

Өмчлөгчийн төлөөлөл:

Б.Золбоо

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Д.Дашнамжилмаа

Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Хэнчмэдэхгүй

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

Эмнэлгийн хамт олны төлөөлөл:

Н.Отгонсүрэн

Нэгдсэн эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

А.Дэлгэрмаа

Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албаны дарга

Олон нийтийн төлөөлөл:

Г.Оюун

Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэгийн гишүүн

Л.Арвинжаргал

Хэрлэн 1 дүгээр сургуулийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Д.Урансайхан

“Ариг өргөжих” төрийн бус байгууллагын нарийн бичиг

2.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/482 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

3. Холбогдох хууль, журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулж, үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



بصر و بصر (بصر) بصر

[illegible]